



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/37

Улаанбаатар хот

┌ Үнэлгээний хороо байгуулах тухай ┐

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийг 2021-2015 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон тус газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Хотын стандартыг сурталчилан таниулах контент боловсруулах ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн зохион байгуулан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажиллахыг Үнэлгээний хороо (Э.Даваахатан)-нд даалгасугай.

ДАРГА  С.ТӨМӨРДУЛАМ

